

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН МЯГМАРЖАВЫН УУГАНБААТАРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ХАНГУУЛАХ							
1.	Арга хэмжээ 1.1 Өмнөговь аймгийн уул уурхайн нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг эрсдэл өндөр үнэлэгдсэн 6 аж ахуйн нэгж байгууллагад хийх 1.Уужим Од ХХК 2.Роял ассет ХХК 3.Траингулар стар нев ХХК 4.Ханбогд инженеринг ХХК 5.Урад гурван сайхан ХХК 6.Энержи ресурс ХХК	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	2023 онд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх шалгалтад 467 объектыг хамруулж, 5043 зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 3625 заалттай 360 албан хаагчид хяналт шалгалт хийгдсэн.	Хяналт шалгалтын удирдамжийг Салбарын хяналтын газрын даргаар батлуулан Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хаданд Нүүрс ачиж буулгах талбайн үйл ажиллагаа явуулдаг 6 ААНБ-уудад хяналт шалгалт хийх	ГБХНХЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан төлөвлөгөөт шалгалт 13-07/05 дугаартай хийх тухай удирдамжийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад суурьшлын бүсд нүүрс ачиж буулгах талбай /гаалийн хяналтын бүс/-н үйл ажиллагаа эрхэлж буй Уужим Од ХХК,Роял ассет ХХК, Траингулар стар нев ХХК, Энержи ресурс ХХК-иудын үйл ажиллагаанд Хөдөлмөрийн харилцааг шалгах 07.1.1 кодтой хяналтын хуудас, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг шалгах 07.1.2 кодтой хяналтын хуудсаар хяналт шалгалт хийж ажилласан. Хяналт шалгалтад Урад 3 сайхан ХХК, Ханбогд инженеринг ХХК үйл	2024.05.09 - 2024.06.01	66,6%

					ажиллагаа зогссон тул хамрагдаагүй. Хяналт шалгалтаар Хөдөлмөрийн харилцаа болон Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар Уужим Од ХХК, Энержи ресурс ХХК-иуд бага эрсдэлтэй Роял ассет ХХК, Траингулар стар нев ХХК-иуд их эрсдэлтэй үнэлэгдсэн. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 32 заалт бүхий 4 албан шаардлага хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.Роял ассет ХХК, Траингулар стар нев ХХК-иудад илүү цагийн хөлсийг хуульд заасны дагуу олгодоггүй зөрчилд улсын ахлах байцаагчийн актаар нийт 116128,0 мянган төгрөгийн акт тогтоон 3000,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулж ажилласан .		
2.	Арга хэмжээ 1.2. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлэх	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	Тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж, байгууллагууд иргэдийг гадаад улсад хөдөлмөр эрхлүүлэх, залилан мэхлэх, иргэдээс зуучлалын хураамж авах зэрэг зөрчил, зар мэдээлэл цөөнгүй ирсэн байна.	Хяналт шалгалтын удирдамжийг Салбарын хяналтын газрын даргаар батлуулан ААНБ-уудад хяналт шалгалт хийх	Салбарын Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/01 дугаартай “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй 64 аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн байна. Дээрх 64 аж ахуйн нэгж, байгууллага нь 2022-2024 оны хооронд	2024.09.01 2024.09.30	100%

					нийт 2667 хүнийг Япон Улсад барилга, эрүүл мэнд, бусад (хүнс, хөдөө аж ахуй, зам засвар, хуванцар, хүнс, нэхмэлийн зэрэг боловсруулах үйлдвэр) салбарт зуучилсан байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын (ахлах) байцаагчийн 15 заалттай 3 албан шаардлага, 36 заалттай 4 зөвлөмжийг тус тус хүргүүлж, биелэлтийг хангуулсан байна.		
3.	Арга хэмжээ 1.3. Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	2023 онд урьдчилан сэргийлэх шалгалтад 467 объектыг хамруулж, 5043 зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 3625 заалттай 360 албан шаардлага хүргүүлсэн.	Салбарын хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хаданд Нүүрс ачиж буулгах талбайн үйл ажиллагаа явуулдаг ААНБ-уудад хяналт шалгалт хийх	ХНХЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан төлөвлөгөөт шалгалт 13-07/05 дугаартай хийх тухай удирдамжийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад суурьшлын бүсд нүүрс ачиж буулгах талбай /гаалийн хяналтын бүс/-н үйл ажиллагаа эрхэлж буй Урчуул отог ХХК-ийн үйл ажиллагаанд Хөдөлмөрийн харилцааг шалгах 07.1.1 кодтой хяналтын хуудас, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг шалгах 07.1.2 кодтой хяналтын хуудсаар хяналт шалгалт хийж ажилласан. Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 3-т заасны дагуу 1500,0 мянган төгрөгийн шийтгэл, илүү цагийн хөлс олгоогүй зөрчилд 167625,0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоон ажилласан.	2024.05.09	100%

4.	Арга хэмжээ 1.4. Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан батлуулах	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	2023 онд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 369 объектыг хамруулж, 3582 зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 2410 заалттай албан шаардлага хүргүүлсэн.	Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулан ХХҮЕГ, Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хэлтсүүдэд хүргүүлэх, хяналт тавих	Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан, батлуулж ХХҮЕГ, Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.	2024.02.07	100%
5.	Арга хэмжээ 1.5. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ Зөрчил арилгалт /хувь/	2023 оны эхний 9 сарын байдлаар төлөвлөгөөт бус шалгалтад 458 объектыг хамруулж, гарсан зөрчлийг арилгуулж ажилласан байна.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг бүрэн хангуулж ажиллана. Хууль сахин мөрдөлтийн түвшинг зорилтод түвшинд хүргэж ажиллана.	Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 39 албан бичиг хүлээн авсанаас хариугүй 14, хариутай 25 албан бичигт хуулийн хугацаанд хариуг өгсөн. Тайлант хугацаанд 29 өргөдөл гомдол хүлээн авч төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж боловсруулан хяналт шалгалт	2024.01.03 - 2024.05.31	100%

					хийсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 23 заалт бүхий 3 албан шаардлага өгч, 6 заалт бүхий 4 дүгнэлтгаргаж зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудаар нийт 5500,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч 4487005,0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоон ажилласан.		
6.	Арга хэмжээ 1.6. Үйлдвэрлэлийн осол хурц хордлогын актыг хянан баталгаажуулах	Хянан баталгаажуулсан актын тоо	2023 оны эхний 9 сарын байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 212 актыг хянан баталгаажуулсан. Үйлдвэрлэлийн осол хурц хордлогод нийт 144 хүн өртөж, үүнээс 12 хүн нас барсан, 71 хүн хүнд бэртсэн, 60 хүн хөнгөн гэмтсэн байна.	Иргэд, ААНБ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлдвэрлэлийн ослын актыг хянан баталгаажуулах Үйлдвэрлэлийн осол хурц хордлогын судлан бүртгэх дүрмийн шинэчлэлд санал өгөх	ГБХНХЯ-ны Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссоос ирүүлсэн хүсэлтийн дагуу 2 үйлдвэрлэлийн ослын актыг хянан баталгаажуулав.	2024.01.02 - 2024.05.31	100%
7.	Арга хэмжээ 1.8.Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилтэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон орон нутгийн салбар нэгжүүдтэй хамтран үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулах	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилт хангалтгүй байна гэх мэдээлэл ирдэг	Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах байгууллагууды н үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, холбогдох саналыг бодлогын газар хүргүүлэх	Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын мөрдөж буй стандартын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/133 дугаар тушаалаар удирдамж, үзлэг шалгалтад хамрагдах 15 асрамж, халамжийн төвийн нэр, үзлэг шалгалт хийх асуумж,		

					судалгааны хамт аймаг, нийслэг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлж, үзлэг шалгалтын үйл ажиллагааг 2024 оны 11 дүгээр сарын 07-22-ны өдрүүдэд зохион байгуулж, танилцуулгыг нэгтгэн дүн шинжилгээ хийн ажиллаж байна.		
Зорилт 2. ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ							
1.	Арга хэмжээ 2.1. Хяналт шалгалтыг төлөвлөх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах	2023 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт-1 ХНХЯ-ны сайдын тушаал-1	2023 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг ХНХЯ-ны А/42 тоот тушаалаар баталсан.	Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх шалгалтын удирдамжийг боловсруулан хүргүүлж, арга зүйгээр хангасан байна.	Салбарын хяналтын газрын 2024 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдламж боловсруулан агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд хүргүүлсэн. Барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад хийх хяналт шалгалтыг эрчимжүүлэх талаар ТНБ-ын албан даалгаварыг боловсруулан хүргүүлсэн.	2024.03.15 - 2024.05.31	100%
2.	Арга хэмжээ 2.2. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулах <i>/Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9.2.1, 5.19/</i>	Салбарын хяналтын чиглэлийн хяналтын хуудасны тоо-2	Салбарын хяналтын чиглэлийн хяналтын хуудасны тоо-2	Хөдөлмөрийн харилцааг шалгах 07.1.1,кодтой хяналтын хуудас, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах	Хөдөлмөрийн харилцааг шалгах 07.1.1,кодтой хяналтын хуудас, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах 07.1.2 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/42 тушаалаар батлуулсан.	2024.02.01	100%

				07.1.2 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлуулан, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах			
Зорилт 3. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
1.	Арга хэмжээ 3.1. Салбарын хяналтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн боловсруулж, батлуулах	Хяналтын хуудас-2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан 1 журам, 1 зааврын ажлын хэсэгт ажилласан.	Салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журмын төсөлд санал өгч тусгуулсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын зохицуулах журмын төсөлд саналд өгсөн:	2024.01.02	80%
2.	Барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ажил олгогч нарт салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгавар хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавьж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт	Салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгавар хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажилласан.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль дүрэм журмын хэрэгжилтийг хангуулсан байна.	Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 07/00-00/01-03 дугаар албан даалгаврыг Барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ажил олгогч нарт хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавьж ажиллаж байна.	2024.02.29	100%
3.	Арга хэмжээ 3.2 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн болон байгууллагын авлигын эсрэг төлөвлөгөөнд тусгагдсан	-	ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргаж хүргүүлсэн байна. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй	ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргаж хүргүүлсэн	2024.02.15	100%

	тогтоомжийг ажиллах	хэрэгжүүлж	холбогдох заалтын биелэлт /		ажилласан байна.			
4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ								
1.	Арга хэмжээ 4.1. 1.Хөдөлмөрийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Америкийн нэгдсэн улсын Хөдөлмөрийн департамент хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж хүргүүлэх 2.Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд байгуулсан Хүүхэд хамгааллын компакт гэрээний дагуу Дэлхийн зөн Монгол ОУБ –тай хамтран ажиллах		Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад орны болон олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, тэдний туршлагыг нэвтрүүлэх,	2023 оноос хойш 2 удаагийн сургалт зохион байгуулагдаж, хөдөлмөрийн хяналтын стратеги төлөвлөлт болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар чадавхижуулсан. Агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн улсын (ахлах) байцаагчид хамрагдсан.	1.АНУ-ын Хөдөлмөрийн департаменттэй байгуулсан хамтран ажиллах санамж бичиг байгуулах бэлтгэл ажлыг хангах 2.АНУ-ын Хөдөлмөрийн департаменттэй байгуулсан санамж бичгийн хүрээнд албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд орж ажиллах 3. Дэлхийн зөн Монгол ОУБ хөдөлмөрийн хэрэгжүүлж буй төслийн арга хэмжээнд оролцох, төсөл хэрэгжүүлэх багийг мэдээллээр хангах, хамтран ажилласан байна.	Хөдөлмөрийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн департамент хооронд 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Америкийн Нэгдсэн Улсын Вашингтон ДС хотод Хөдөлмөрийн департаментын урилгаар тус яамны бодлого, үйл ажиллагаатай танилцах, хөдөлмөрийн асуудлаарх хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн шинэчлэл, уул уурхай, хүнд үйлдвэр болон бусад аж үйлдвэрийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөрийн салбарын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцох, туршлага судалсан. 2. Олон улсын хөдөлмөрийн байгууллага 2002 оноос хойш жил бүрийн 6 сарын 12-ны өдрийг "Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдөр" болгон олон улсын түвшинд хүүхдийн хөдөлмөрийг устгахын төлөө ажиллаж байгаа билээ. Энэ жил “Амлалтаа биелүүлье.	2024.02.26	100%

					Хүүхдийн хөдөлмөрийг устгая!” уриа дор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ОУХБ-ын Европын Холбооны санхүүжилттэй “Зохистой хөдөлмөр ба худалдаа” төсөл, Монгол Улс болон АНУ-ын Төрийн Департаментын хооронд байгуулсан Хүүхэд хамгааллын компакт түншлэлийн хүрээнд АНУ-ын Төрийн Департаментын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх газрын санхүүжилтээр Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, Азийн Сан хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” (ХХТК) төсөлтэй хамтран “Амлалтаа биелүүлье. Хүүхдийн хөдөлмөрийг устгая” уриа дор хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар зөвлөлдөх уулзалт хамтран зохион байгууллаа.		
2.	Арга хэмжээ 4.3. Хяналт шалгалтын үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах, иргэд, ААНБ-ыг соён гэгээрүүлэх мэдээ мэдээллийг хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах суваг, сонирхолд тулгуурлан ойлгомжтой байдлаар хүргэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Хамрагдсан иргэд, ААНБ-ын тоо	2023 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим санд /https://mlsp.gov.mn/ Хөдөлмөрийн тухай хуулийн богино хэмжээний 10 видеог байршуулан нийт 4706 хандалт авсан байна.		1. Европын Холбооны Улсын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан нэгдсэн сургалт болон модуль сургалтын мэдээллийг ГБХНХЯ-ын вебсайт https://mlsp.gov.mn/content/detail/3523 болон ОУХБ-ын албан	2024.12.01	100%

--

	ёсны фасебүүк хуудсаар түгээсэн. 2. Албадан хөдөлмөр, түүний эрсдэлийг олон нийт, ажилтнуудад таниулах цуврал 5 рийлсийн текстийг боловсруулж, видео бичлэгийг бэлдэж, ГБХНХЯ болон ОУХБ-ын албан ёсны фасебүүк хуудсаар түгээхэд бэлэн болгосон.		
--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын өгсөн үүрэг даалгаварын дагуу Дашваанжил ХХК-д төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	0	0	Хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах	ХНХЯ-ны салбарын хяналтын газрын дарга, УУХҮЯ-ны Салбарын хяналтын газрын дарга, ЗТХЯ-ны Салбарын хяналтын газрын дарга нарын баталсан удирдамжийн Дашваанжил ХХК-д төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж 26 заалт албан шаардлага хүргүүлсэн. Шөнийн цагийн нэмэгдэл хөлс олгоогүй зөрчилд улсын ахлах байцаагчийн актаар 161642,5 мянган төгрөгийг нөхөн олгуулахаар тогтоож бүрэн барагдуулсан байна.	2024.02.01- 2024.03.15	100%
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор холбогдох	Албан даалгава р-1	2023 онд Улсын ерөнхий байцаагчийн 07/00-00/001 албан даалгаварыг		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангаж, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох,	2024.03.15	100%

	байгууллагуудад албан даалгавар хүргүүлэх		хүргүүлсэн байна.		үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Салбарын улсын ерөнхий байцаагчийн 07/00-00/001-03 дугаартай албан даалгаврыг БХБЯ –ны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд, МҮЭХ, МАОЭНХ, МҮХАҮТ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар зэрэг байгууллагад тус тус хүргүүлсэн.		
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Гандантэгчилэн хийдийн лам хүүхдүүдийн дотуур байранд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/01 дүгээр “Албан даалгавар”-ын хэрэгжилтийг шалгах ажлын хэсэгт ажиллах	0	0	0	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/01 “Албан даалгавар”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Төв-Гандантэгчэнлин хийдэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтын үеэр Гандантэгчлэн хийдийн холбогдох албан тушаалтнуудад илэрсэн зөрчил дутагдлыг хэрхэн арилгах, дацангуудын гал тогоонд ажиллагсадын хөдөлмөрийн эрүүл ахуй, тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, стандарт шаардлагыг хангаж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	2024.01.25	100%

					Шалгалтын танилцуулгыг нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн.		
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан Хяналт шалгалт хийх нийтлэг журмын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар, түүний харьяа дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд ажиллаж буй хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын (ахлах) байцаагчдын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, түүний үр дагаварт үнэлгээ хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, цаашид авах арга хэмжээний санал дүгнэлт боловсруулах зорилгоор хяналт үнэлгээг зохион байгуулах	0	0	0	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/31 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын /ахлах/ байцаагчдын 2024 оны эхний 8 дугаар сарын байдлаарх хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, хэрэгжилт хангагдаагүй, үр дүн тодорхойгүй, хүрч чадаагүй зорилт арга хэмжээний шалтгаан, нөхцлийг тодорхойлох, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах, улсын байцаагчдын үйл ажиллагаа нь чиг үүрэг хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байгаа эсэх болон түүний үр дагаварт үнэлгээ хийсэн. Үнэлгээний хүрээнд СУЕБ-ийн 2024 оны 07/00-00/001-09 дугаартай Сахилга хариуцлага, бүтээмжийг дээшлүүлэх тухай албан даалгаврыг хүргүүлсэн.		
5.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. ГБХНХЯ-нд Хэнтий аймгийн Бэрхийн уурхайн 88 уурхайчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс ирүүлсэн гомдлын дагуу байгуулагдсан ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын дагуу 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.1, 97.1.2 дахь заалтын дагуу хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан	0	0	0	Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байсан 88 уурхайчдын 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.1, 97.1.2 дахь заалтын дагуу хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан иргэдэд олгох нөхөн төлбөрийн тооцооллыг гарган ажлын хэсэгт хүргүүлсэн.		

	иргэдэд олгох нөхөн төлбөрийн тооцооллыг гаргах, хянах						
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ №1 Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдын чадавхжуулах сургалт, дадлага эзэмшүүлэх нэгдсэн сургалт, семинарт хамрагдах	Хөтөлбөрийн хүрээнд шинэ мэдээлэл авч, дадлага эзэмшсэн байна.	2023 онд гадаадын 1, үндэсний 4 чадавхжуулах сургалтад хамрагдсан.	Төсөл, хөтөлбөрийн хүрээнд шинэ мэдээлэл авч, дадлага эзэмшсэн байна.	1.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын үндсэн эрхийг хангах зорилгоор албадан хөдөлмөрийг таних, илрүүлэх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хяналтын хуудас болон хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдад зориулсан сургалтын модуль хөтөлбөр, гарын авлага, аргачлал боловсруулах ажлын хэсгийг ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/96 дугаар тушаалаар байгуулсан. Олон улсын зөвлөх Йоханнес Ян Ван Де Глинд нь Монгол Улсад 2024 оны 05 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулсан хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчидын сургалтад хамрагдсан. 2.“Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл”-ийн хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 115 улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад 2024.11.25-2024.11.26-ний өдрүүдэд хамрагдаж, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн. 3.“Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг	2024.05.17	100%

					дэмжих нь төсөл"-ийн хүрээнд ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх сургалтын шинэ модуль хөтөлбөрөөр 30 сургагч багшийг бэлтгэх 16 цагийн сургалтад хамрагдсан.		
2.	Арга хэмжээ №2 "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-т Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг хангах арга хэмжээний хүрээнд Монгол бичиг бие даан сурах.	Монгол бичгээр алдаагүй зөв бичиж, уншиж сурсан байна.	Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй.	Монгол бичгээр алдаагүй зөв бичиж, уншиж сурсан байна.	Монгол бичгийг онлайнаар бие даан судалж байна. Унших, бичих чадвар өмнөх түвшингээсээ сайжирсан.	2024.01.02 2024.12.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

(Албан тушаал)

 / М.УУГАНБААТАР /
(Нэр, гарын үсэг)

(Огноо)